

ХҮННҮГИЙН ХОВОР СОНИН ОЛДВОР

Д. НАВААН
МУИС-ийн антропологи-археологийн тэнхим

Төв Азийн асар өргөн уудам нутаг дэвсгэрт ойролцоогоор 3-4000 жилд Алтайн язгуур хэлтэн олон овог аймгуудыг багтаасан эртний түүх соёлын арвин их дурсгал, ул мөр үлдээсэн хүннү улс оршин тогтох байв. Тэдгээрийн дотор уугуул нутгийн цар хүрээ, хүн амын дийлэнх, зан заншлын хэв шинжээр адил нь Монгол овогтны өвөг дээдэс байж, өөрсдийн нүүдэл соёл иргэншлээ бүтээж байлаа.

Эртний Хятадын сурвалж бичгүүд-Ши цзи зэрэг Хүннү улсыг туурга тусгаар түүх, соёл, эдийн засгийн хувьд биеэ даасан байсан тухай- умар зүгийн нум сум агссан улсыг Хүннүгийн хууль захирна урт хотоос дотогших дээл, малгайн улсыг хан улсын хууль-захирах утгаар хааны айлтгалд тодорхой утгаар дурдсан буй. Түүнчлэн сурвалж бичигт хүннүгийн нутаг ус, эрхлэх аж ахуй, гарал үүсэл, зан үйл зэргийг өгүүлсэн буй. Умар зүгийн нүүдэлч олон овог аймгуудын тухай дурьдахдаа; Тэдгээр нь байгаль орчны ая талыг дагаж, уугуул нутгийн гаралтай таван төрлийн мал-адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа (бусад) өсгөн үргүүлж өвсний соргог, усны тунгалгийг бараадан, нутаг сэлгэн амьдарна гэсэн байдаг.

Мөн тэд малын аж ахуй эрхлэхийн зэрэгцээ араатан жигүүртэн агнаж, амжиргаанд хэргэлнэ гэсэн буй. (Хүннүгийн түүхийн эмхэтгэл материал)

Эртний хүннүгийн тухай судлал зуун жилийн нүүр үзэж, олон тооны эрдэмтэд, археологичид, чамлалтгүй олон бүтээл, туурвил гаргаж хүннү гүрний тухай, ойлголт, мэдлэгийн санч баяжаасаар байгаа юм.


Хүннү улсын нутгийн төв одоогийн Монгол улсын дэвсгэрт онолдож байгаагийн хувьд Монгол оронд 1924-25 онд П.К.Козлов Ноён уулын булш малтаж, Маодунь Шанью хааны (Сайнхаан) дурсгал хэмээн анх мэдээлснээс хойш 70 гаруй жил өнгөрөхөд манай оронд явуулсан археологийн малтлага шинжилгээний шинэ тулгар материал хүннү судлалын цар хүрээг тэлэхэд үнэлж үзхүйц хувь нэмэр оруулсаар байгааг дурдууштай.

Нэн ялангуяа, МЗТСХЭ (Монгол Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедиц-хуучин нэрээр) хүннүгийн олон арван жирийн булш малтан (монгол, орос, эрдэмтэд монгол-унгар эрдэмтэд, Х.Пэрлээ, Н.Сэр-Оджав, Д.Наваан, Д.Цэвээндорж, Ц.Доржсүрэн, А.П.Окладников, В.В.Волков, П.Б. Коновалов, И.Эрдели /унгар/) Хүннүгийн эдийн соёлын үнэт ховор хур материал илэрүүлж, эрдэм шинжилгээний ном, зохиол өгүүлэл, нийтэлсэн байна.

Сүүлийн үед Монголын археологичид бие даан судалгаа явуулан шинэ шинэ газар нутагт урьд өмнө олоогүй, булш оршуулага нээж, хүннүгийн археологийн материалыг тооноос чанарт хүргэсээр байна.

ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс 1980 гаруй оноос 1990 онд Ховдын хязгаарт (Ховдын Манхан сумын Тахилтын хотгорт) малтаж шинжилсэн язгууртны 1,2-р том булшны эдийн соёлын дурсгал, П.К.Козловын дараах шинэ томоохон ажил болсон юм. (Хүннүгийн өв соёл-1999 он)

Сүүлийн жилүүдэд МУИС-ийн НУФ-ийн дэргэд Антропологи-археологийн тэнхим байгуулагдан жил бүр оюутны хээрийн дадлага явуулан хүннүгийн үеийн хэдэн арван булш малтаж, эрдэм шинжилгээний ач холбогдол бүхий олон сонин ховор олдвороор оюутнуудын сургалт-үзүүлэн материал-сан хөмрөг буй болгож байна. Энд бид урьд өмнө хүннүгийн эдийн соёлд холбогдох хүрэл лууны толгой, өвөрмөц мөнх зулын вааран цөгц, анх удаа олдож буй цөгцөн ёроол суурьтай хүрэл



15-р зураг. Радиокарбоны шинжилгээний график

Дээжийн дугаар: Kar.2/132

Лабораторийн дугаар: Erl-3308

Дээжийн хэмжигдэхүүн: 974 ± 40 радиокарбон жил

Калибрийн тогтмол хэмжигдэхүүний наслал: $864 \text{ BP} \pm 78$ жил

68,3 % магадлалтай (1 Sigma)

МЭ 1017 - 1052 он

МЭ 1085 - 1119 он

МЭ 1137 - 1158 он

95,4 % магадлалтай (2 Sigma)

МЭ 1008 - 1165 он

тогоо, бичиг тэмдэгтэй ваар, зэргийг дурдахын хамт, нэгэн ховор сонин эдийн дурсгал ясан сийлбэрийг толилуулж байна. (Зураг)

2001 оны зун, МУИС-ийн НУФ-ийн Антропологи-Археологийн тэнхмийн оюутнуудын хээрийн дадлага явуулан Архангай аймгийн Батцэнгэл сумын Эмээл толгойн Хүннү булш З-дугаараас гарсан эрэгтэй-эмэгтэй хоёрын хамт уул ховор сонин ясан сийлбэр олдсон юм.

- Бод малын хавирганы ясан дээр 25.5 см урт, 4.5 см өргөн толигорт утга бүрэн төгс сийлбэр үйлдсэн байна. Уул сийлбэр дурсүүдийн дунд зүүх ? зориулалттай нүх буй сийлбэр зураасыг нарийн хурц үзүүртэй багажаар хийжээ. Дурсүүдийн төв хэсэгт хэмжээгээр том их биеийг ташуу зураасаар зурчин хээлсэн морь ? сүүлгүй, ан амьтан, чоно? Түүний өмнө энэ амьтны толгой, чихтэй адил, их биеийг дээрх амьтных шиг зурчсан тул энэ амьтны үр төл баймаар жижиг дүрс буй. Энэ амьтан тонгойн ойртож буй мод бол орой, нарийн үзүүрээр дорогш харсан, мөчир, гишүүтэй болно. Гэтэл, сийлбэрийн баруун гар талд мөчир, гишүү нь хэв ёсоор байгаа мод, түүнд ойртон ирж буй томруун бодьтой дурсэлсэн хэв маяг нь чоно (үнэг?) хэлбэрийн амьтан, түүний сүүл дээр дан зураасаар ёстой сагсгар үнэгэн сүүл нэмжээ. Сийлбэрийн зүүн гарт мод өөд хандсан үнэг, чоно? Бүдэг дүрс, дээд талд дөрвөлжин (орон гэр?) утга санаа ойлгомжгүй, битүү зууван дүрс (ус?) зэрэг нь эртний сийлбэрчний бүхэл бүтэн оюун санааны цогц уран бүтээл юм.

Эгэл мөртлөө, туйлын ховор дүрсүүд оруулж орчин цагийн зураасан зургийн хэлбэр, талбайн зайл сайн зохиомжилж, мод, амьтан, тэдгээрийн том жижиг, харьцааг зөв гаргасан санагдана.

Хүннү уран сийлбэрчийн зохиол-сийлбэр бол бүхэлдээ байгаль орчин, орон зайл, газар, тэнгэр, мод, ургамал, ан амьтан, хишиг буяны утга санаа тод юм.

Уул сийлбэрийн нүхний талаар гэвэл, гэр оронд юм уу, биендээ зүүж байсан элэгдэл байхгүй тул, (Буган хөшөөний шиг), нар сар байж болмоор. Мэрэг, төлөг, ид шидийн нүх ч байж болно. Ан гөрөө, заяа зөн хардаг байж болно. Энэ сонин дурсгалын хамт чонын нүхтэй шагай олдсон нь ясан сийлбэр дурсгалыг маргах аргагүй анчин хүний сүлд, нандин эд өлөг гэдгийг улам үнэмшүүлж байна. Чоно эртэй, тэнгэрлэг амьтан, анчин хүний цог хийморь, эртний овог аймаг, хөх чоноор удам угсаагаа удамлан домоглодог.

Монгол овогтны дээд өвөг Хүннү хөх чоно сүлдтэн байжээ. Үүний нэг гэрч бол Хүннү жирийн анчин хүний оршуулгаас ховор нандин эд өлгийн дурсгал гарсан нь өвөг монгол овогтны дээд Бөртөчину, Гоо Маралын уламжлалт Чингис хааны уг алтан урагтай холбогдон ирж байгаа буюу.

Ном зүй

- Г.Сүхбаатар. Монголын түүхийн дээж бичиг. 1992.
- Д.Наваан. Хүннүгийн өв соёл. 1999.
- Д.Наваан. Археологийн ваар савны урлаг. 2002.
- МУИС. НУФ. Антропологи-Археологийн тэнхим хээрийн шинжилгээний дадлага тайлан, мэдээ. 2001. зурагт хуудас
- МУИС. НУФ-ийн санд байгаа, боловсруулалтын материал, зураг, бие олдвор

